

## ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ, ШҮҮМЖ

**Н**ээлттэй Нийгэм Форумаас “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хууль”-ийн төслийн хэлэлцүүлгийг төрийн бус байгууллага, хуульчдын оролцоотойгоор 2015 оны 11-р сард зохион байгууллаа. Хэлэлцүүлгийн явцад гарсан санал, шүүмжийг нэгтгэн танилцуулж байна.

Хуулийн төслийн хэлэлцүүлэгт хуулийн их дээд сургууль, судлаачдаас Б.Базар (Эрх зүйч), Д.Буян, Ж.Даваасүрэн (Хуульч), Ц.Өлзийтогтох (МҮИС-ийн Хууль зүйн ухааны сургууль), төрийн бус байгууллагаас Б.Анхныбаяр (Захиргааны шинэ санаачилга), Ш.Афиунаа, Ц.Сарантуяа (Монголын эмэгтэйчүүдийн хөдөлмөрийг дэмжих холбоо), Б.Баттогтох (МонАме судалгааны төв), А.Бор (Их бага баяншаарга), В.Ганболд, Д.Орхонтуул (Монголын байгаль орчны төлөөх хуульчдын холбоо), А.Долгор, Н.Заяа (Хөгжлийн хэлхээ), Д.Мөнхтуяа (ЛГБТ төв), Д.Мөнхцэцэг (Ирээдүйн босго), Ц.Нафангэрэл (Монголын хуульчдын холбоо), Ч.Одончимэг (Хүчирхийллийн эсрэг үндэсний төв), А.Оюунчимэг (Булаг шанд гол мөрний эхийг хамгаалах сан), Ч.Сэмжидмаа (Сэтгэл зүйн мэдрэмж), Я.Цэрэнханд (Ангир нүдэн мөндөөхэй хөдөлгөөн), М.Чинзориг (Монголын байгаль орчны иргэний зөвлөл), Б.Энхмаа (Хүний аюулгүй байдлын судалгааны төв), Б.Энхцэцэг (Хүний эрх хөгжил төв) болон Б.Хишигсайхан (Нээлттэй Нийгэм Форум) нар оролцлоо.

### Нэг. ЕРӨНХИЙ САНАЛ, ШҮҮМЖ

1. Хуулийн төсөлд нийтийн ашиг сонирхлыг нэхэмжлэн хамгаалах боломжийг нээж, холбогдох бусад зохицуулалтыг тусгасан нь тун чухал ахиц дэвшил болжээ. Түүнчлэн давах, хяналтын шатны шүүх нийтийн ашиг сонирхлыг төлөөлөх нэхэмжлэлийн хувьд хэргийг гомдол гаргагчийн гомдлын хүрээнд бус бүхэлд нь хянахаар зохицуулсныг сайшааж байна.
2. Захиргааны хэргийн шүүхээс гарах шийдвэрийн төрөл нэг бүрийг тодорхой заасныг дэмжиж байна.
3. Хуулийн төсөлд шүүхийн шийдвэрийг биелүүлээгүй албан тушаалтанд мөнгөн албадлага ногдуулах, сахилгын шийтгэл ногдуулахыг дээд шатны байгууллага; албан тушаалтанд үүрэг болгох болон үүргээ биелүүлээгүй бол дээд шатны албан тушаалтанд өөрт нь сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болохоор зохицуулсныг сайшаан дэмжив. Түүнчлэн, шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагааг зөвхөн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад хариуцуулах бус шүүхийн оролцоог нэмж хуульчилсныг дэмжиж байна.
4. Хуулийн төсөлд хэргийн оролцогчийн эрх, үүрэг, хэргийн оролцогч төлөөлөгчийн эрхийг дуусгавар болгох болон төлөөлөн оролцож болохгүй нөхцөл байдлын талаар тусгасныг зүйтэй гэж үзэв. Түүнчлэн, өмгөөлөгч нь хэргийн материалтай танилцах боломжит хугацаагаар хангуулах эрхтэй байхаар зохицуулсан нь иргэний өмгөөлүүлэх эрхийг хангасан, энэ талаарх олон улсын стандартад нийцсэн зохицуулалт болжээ.

5. Хуулийн төсөлд нэхэмжлэгч иргэн, хуулийн этгээд нь зөвхөн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулах бус зөрчигдөж болзошгүй эрх, хууль ёсны ашиг сонирхлоо хамгаалуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах эрхтэй байхаар зохицуулсан нь иргэн, хуулийн этгээдэд шүүхийн бүрэн хамгаалалт авах боломж бүрдүүлжээ.
6. Хуулийн төсөлд цахим нотлох баримтын талаар дурдсан ч цахим нотлох баримтыг хэрхэн цуглуулах, хамгаалах, үнэлэх талаар тусгайлан зохицуулаагүй нь учир дутагдалтай.
7. Хуулийн төслийн 52.5.5-д “... хангалттай ашиг сонирхлыг илэрхийлсэн байх ...” гэсэн нь шинэ ойлголт байх тул ойлгомжгүй, тодорхой бус байна.

**Санал:** Ойлгомжтой томъёолох, эсхүл тайлбарлах

8. Хуулийн төслийн танилцуулга хэт ерөнхий байна. Үүний улмаас шинэлэг зохицуулалтыг олж харж санал өгөхөд хүндрэлтэй байна.

**Санал:** Хуулийн төслийн танилцуулгад шинээр орсон зохицуулалт бүрийг тусгайлан танилцуулах

## Хоёр. ТУСГАЙ САНАЛ, ДҮГНЭЛТ

ХУУЛИЙН ТӨСӨЛД НЭМЭХ ЗААЛТ			
№	Зүйл, хэсэг	Санал	Тайлбар, үндэслэл
1	4.1	нас, хүйс гэсний дараа “бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, хөгжлийн бэрхшээлээр” гэж нэмэх	Иргэнийг бэлгийн чиг баримжаа, хүйсийн баримжаа илэрхийлэл, хөгжлийн бэрхшээлээр ялгаварлан гадуурхах хандлага түгээмэл байгаа билээ. Тиймээс үүнийг хуулийн төсөлд нэмж тусгах нь эдгээр цөөнхийн эрхийг хүндэтгэж, хамгаалсан хэрэг юм.
2	14.5	“холбоотой болон” гэсний дараа “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гаргах нэхэмжлэл” гэж нэмэх	Нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргах тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй байдлаар зохицуулах нь зүйтэй. Тийнхүү зохицуулах нь нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах үзэл баримтлалд нийцэх юм. Учир нь, энэ тохиолдолд нэхэмжлэл гаргаж буй этгээд өөрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж нэхэмжлэл гаргаагүй тул тухайн этгээд захиргааны үйл ажиллагааны талаар мэдсэнээс хойш 30 хоногийн дотор нэхэмжлэл гаргаагүй нь эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийтийн ашиг сонирхлыг шүүхээр хамгаалах явдлыг хязгаарлахад хүргэх ёсгүй.

3	54.3	54.3 дахь заалттай холбоотой “Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэртэй хэрэгт гуравдагч этгээдээр оролцвол зохих этгээд уг асуудлаар шүүхэд нэхэмжлэл гаргах тохиолдолд шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэх” агуулгатай хуулийн заалт нэмэх	Хуулийн төсөлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд гуравдагч этгээдээр оролцвол зохих этгээд оролцож чадаагүй тохиолдолд хуулийн төслийн 54.1.6 дахь заалтад хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэр, шүүгчийн захирамж байгаа нь гуравдагч этгээдийн нэхэмжлэлийг хүлээж авахаас татгалзах үндэслэл болохгүй байхаар заасан нь дэмжүүштэй үзэл санаа юм. Үүнтэй холбоотой гуравдагч этгээд тийнхүү нэхэмжлэл гаргасны дагуу захиргааны хэрэг үүссэн тохиолдолд түүнд сөрөг үйлчлэл бүхий шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн ажиллагаа түдгэлзэх нь түүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах тул дээрх агуулгаар хуулийн заалт нэмэх нь зүйтэй. Учир нь, энэ тохиолдолд хуулийн хүчин төгөлдөр шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагаа түдгэлзэхгүй бол шүүхэд шинээр нэхэмжлэл гарган явж буй гуравдагч этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тус шүүхийн шийдвэрийн гүйцэтгэх ажиллагааны улмаас хохирно.
4	91.1, 91.2	Хуулийн 91.1, 92.2 дахь заалт нийтийн ашиг сонирхолтой холбоотой захиргааны хэрэгт хамаарахгүй талаар хуулийн заалт нэмж тусгах.	Нийтийн ашиг сонирхлыг шүүхэд төлөөлөн хамгаалах асуудалд нэхэмжлэгч хуулийн этгээдийг төлөөлөх иргэд дарамт, шахалтад орсны улмаас хэргийг хянан хэлэлцэх шүүх хуралдаанд оролцож чадахгүй байх боломжтой. Иймд тус хэргийг хянан шийдвэрлэх шүүх хуралдаанд нэхэмжлэгч ирээгүй тохиолдолд шүүх нэхэмжлэгчийг оролцуулалгүйгээр хэргийг хянан шийдвэрлэхгүй байх нь зүйтэй.
5	124.1	“32.1, 32.7” гэж нэмэх	Хэргийн оролцогчийн нотлох баримт гаргуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд хэргийн оролцогчид гомдол гаргах эрхтэй байхаар зохицуулах нь хэргийн оролцогчийн эрхийг хамгаалсан, захиргааны хэргийн шүүхийн нотлох баримт цуглуулах үүргийг бататгасан хэрэг болох бөгөөд нотлох баримтыг дутуу цуглуулсан үндэслэлээр шүүхийн шийдвэрийг хүчингүй болгож, хэргийг дахин хэлэлцүүлэхээр анхан шатны шүүхэд буцааж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны хугацаа алдахаас сэргийлэх юм. Хэрэв гомдол гаргах эрхтэй шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг хязгаарлах үзэл баримталж байгаа бол нотлох баримт цуглуулах тухай хүсэлтийг шийдвэрлэсэн захирамж, тогтоолд гомдол гаргах эрхгүй байхаар зохицуулах ч хэргийн оролцогчийн гаргаж өгсөн баримтыг хэргийн нотлох баримтаас хассан шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолд гомдол гаргах эрхтэй байх нь зөв юм.

### ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ХАСАХ ЗААЛТ

6	32.6	32.6 дахь заалтыг бүхэлд нь хасах	Шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болсны дараа бичмэл нотлох баримтын эхийг түүнийг гаргаж өгсөн этгээдийн хүсэлтээр буцааж өгөх харилцааг хуулийн төслийн 38.5 дахь заалтад зохицуулсан байна. Мөн 32.6 дахь заалтад “шаардлагатай гэж үзвэл хуулбарыг хэрэгт хавсаргах” буюу шаардлагагүй гэж үзвэл хуулбарыг хэрэгт хавсаргахгүй байж болох, хавсаргахдаа нотариатаар гэрчлүүлээгүй хуулбарыг хавсаргах боломжтой байдлаар зохицуулсан нь буруу юм. Хуулийн хүчин төгөлдөр болсон шүүхийн шийдвэр шинээр илэрсэн нөхцөл байдлын талаар хянагдах тохиолдолд хэргийн нотлох баримт бүрэн шаардлагатай тул баримтын хуулбарыг буцааж өгөх тохиолдолд нотариатаар гэрчлүүлсэн хуулбарыг хэрэгт үлдээх нь зүйтэй.
---	------	-----------------------------------	--

7	117.5	Тус заалтыг бүхэлд нь хасах	Тус заалтын дагуу давж заалдах гомдол гаргагч нь хэргийг давж заалдах шатны шүүх хуралдаанаар хэлэлцэхэд өөрөө оролцох эсвэл төлөөлөгч, өмгөөлөгчөө биечлэн оролцуулах тухай хүсэлтээ шүүхэд бичгээр гаргаагүй бол Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхээс давж заалдах гомдол гаргагчид шүүх хурлын товыг мэдэгдэх үүрэг хүлээхгүй байх үр дагавартай байна. Ингэснээр давж заалдах гомдол гаргагчийн шүүх хуралдаанд оролцох эрх, боломжийг хязгаарлаж байна. Иймд иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлоо шүүхээр хамгаалуулах явцад биечлэн оролцох эрхэд зүй бус хязгаарлалт болж байгаа энэ заалтыг хасах саналтай байна.
8	119.1	Тус заалтын “хуралдаанд биечлэн оролцох хүсэлтээ бичгээр гаргасан тохиолдолд” гэсэн хэсгийг хасах	Хуулийн төслийн 117.5 дахь заалтыг хасах саналын тайлбар, үндэслэлтэй ижил
9	138.8	Тус заалтыг бүхэлд нь хасах	Хуулийн төслийн 138.8 дахь хэсэгт “Шүүхийн түр хугацааны шийдвэр гүйцэтгэхэд энэ хуулийн 138 дугаар зүйл хамаарахгүй” гэж заасан байна. 138 дугаар зүйл нь шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх тухай зохицуулалт. Иймд шүүхийн түр хугацааны шийдвэр буюу нэхэмжлэгчид шүүхийн урьдчилсан хамгаалалт олгож буй захиргааны үйл ажиллагааны биелэлтийг түдгэлзүүлэх шүүгчийн захирамж, шүүхийн тогтоолыг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар албадан гүйцэтгэхгүй байх агуулгатай болсон байна. Хэрэв тус асуудлаар шүүхийн шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлага гардаггүй бол хуулийн төсөлд дээрх байдлаар тусгаагүй ч албадан гүйцэтгэх ажиллагаа явагдахгүй. Харин албадан гүйцэтгэх шаардлагатай тохиолдолд тус боломжийг хаасан хэрэг болох байна. Тухайлбал, захиргааны бодит үйлдэл бүхий акттай маргах тохиолдолд актын биелэлтийг түдгэлзүүлэх шийдвэрийг албадан гүйцэтгэх шаардлага гарна гэж үзэж байна.

### ӨӨРЧЛӨН НАЙРУУЛАХ САНАЛ

10	14.6	“нэг жилийн дотор нөхөн сэргээж болно” гэж заасныг “таван жилийн дотор нөхөн сэргээж болно” гэж өөрчлөх	Шүүхэд нэхэмжлэл гаргах хөөн хэлэлцэх хугацааг хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хэтрүүлснийг шүүхээр сэргээлгэх хугацааг нэг жилээр хязгаарласан нь богино хугацаа байх тул Иргэний хуулийн ерөнхий хугацаа болох 5 жилийн хугацаагаар тогтоох нь зүйтэй.
----	------	---	--

11	18.4	Тус заалтыг бүхэлд нь “нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргасан этгээд үндэслэлгүйгээр нэхэмжлэлээс татгалзах, давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлоос татгалзах эрхгүй бөгөөд нийтийн ашиг сонирхлыг хамгаалахтай холбоотой хэрэгт нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүй нь нэхэмжлэлийг буцаах үндэслэл болохгүй” гэж өөрчлөх	Хуулийн төслийн 18.4 дэх заалтад нэхэмжлэгч үндэслэлгүйгээр нэхэмжлэлээс татгалзах эрхгүй байдлаар зохицуулсан байна. Энэ нь маш ухаалаг үзэл баримтлал юм. Учир нь, нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн шүүхэд нэхэмжлэл гаргаж буй тул янз бүрийн шахалт эсвэл нэхэмжлэл гаргагч хувийн ашиг хонжоо авах зорилгоор шүүхэд нэхэмжлэл гаргасны дараа гаргасан нэхэмжлэлээс татгалзсанаас болоод нийтийн ашиг сонирхол хохирох, уг асуудлаар өөр бусад этгээд дахин шүүхэд нэхэмжлэл гаргах, маргах эрхгүй болох ноцтой сөрөг үр дагавартай. Гэвч, мөн адил дээрх үр дагаварт хүргэж болох давж заалдах болон хяналтын журмаар гаргасан гомдлоосоо нэхэмжлэгч татгалзах, нэхэмжлэгч шүүх хуралдаанд ирээгүй гэх үндэслэлээр нэхэмжлэлийг буцаах асуудлыг хуулийн төсөлд хязгаарлаагүй байна. Нэхэмжлэгч хариуцагчийн дарамт, шахалтад орох эсвэл хувийн ашиг хонжооны үүднээс анхан шатны шүүх хуралдаанд ирэхгүй байж нэхэмжлэлийг буцаалгах эсвэл нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр, магадлалд гаргасан давж заалдах болон хяналтын гомдлоос татгалзан нийтийн ашиг сонирхлыг хохироох боломжтой тул хуулийн заалтыг дээрх байдлаар өөрчлөн найруулж, нийтийн ашиг сонирхол хохирох эрсдэлийг хязгаарлах нь зүйтэй.
12	32.4	“Шүүх хуралдаан товлохоос өмнө” гэж заасныг “Шүүх хуралдаанаас өмнө” гэж өөрчлөх	Хэргийн оролцогчид нотлох баримт гаргаж өгөх эрхийг шүүх хуралдаан товлон зарлахаас өмнө гэдэг байдлаар хязгаарлах бус шүүх хуралдаанаас өмнө гаргах, өмнө гаргаж өгөх боломжгүй хүндэтгэн үзэх шалтгаан байсан бол шүүх хуралдааны үеэр гаргаж өгөх боломжтой байдлаар буюу Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.7, 105.2 дахь заалтуудтай ижил байдлаар тусгах нь хэргийн оролцогчийн нотлох баримт гаргаж өгөх, шүүхийн нотлох баримт цуглуулах үүрэгтэй уялдах юм.
13	38.2, 38.3	Тус заалтуудыг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 44.2, 44.4 дэх заалтуудыг тайлбарласан Улсын дээд шүүхийн тайлбартай нэгэн адил агуулгаар өөрчлөн найруулах	ИХШХШТХуулийн 44.2, 44.4 дэх заалтуудыг Улсын дээд шүүхийн 2009 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 30 дугаар Тогтоолоор тайлбарлахдаа архивын “хуулбар үнэн” тамга дарах нь хэргийн оролцогч бус этгээдэд, нотариатаар гэрчлүүлэх шаардлага нь хэргийн оролцогч этгээдэд хамааралтай байдлаар тайлбарласан.
14	52.2.5	“... буюу чөлөөлөгдсөн баримт” гэснийг “баримт, улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх, хойшлуулах тухай хүсэлт, баримт” гэж өөрчлөх	Шүүхэд нэхэмжлэл гаргахдаа Улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдсөн баримт гаргаж өгөх боломжгүй байдаг. Учир нь улсын тэмдэгтийн хураамжаас чөлөөлөх асуудлыг шүүгч шийдвэрлэх билээ. Нэхэмжлэгч нь улсын тэмдэгтийн хураамжийг төлөх боломжгүй нөхцөлд төлсөн баримт шаардах бус хураамж төлөхөөс чөлөөлөгдөх эсвэл хойшлуулах тухай хүсэлт, тэмдэгтийн хураамжаас чөлөөлөгдөх үндэслэлийг харуулах баримт гаргаж өгөх байдлаар зохицуулах нь зүйтэй.

15	53.1	“... нарийн бичгийн дарга” гэж заасныг “шүүхийн мэдээлэл лавлагаанд” гэж өөрчлөх	Шүүхэд гаргасан нэхэмжлэлийг Шүүх хуралдааны нарийн бичгийн дарга хүлээж авдаггүй. Шүүхийн мэдээлэл лавлагааны ажилтан хүлээж авдаг. Иймд одоогийн байгаа практиктаа нийцүүлэх.
16	61.2	“... хуульд заасан үндэслэлээр” гэж заасныг “нэхэмжлэгчид холбогдуулж” гэж өөрчлөх	Хуулийн төслийн агуулга нь хэм хэмжээний актыг зөвхөн хуульд заасан буюу материаллаг эрх зүйн хуульд заасан тохиолдолд түдгэлзүүлэхээр заажээ. Гэвч одоогийн байдлаар аль ч хууль хэм хэмжээний актын талаар ялангуяа актын биелэлтийг түдгэлзүүлэх талаар заадаггүйг анхаарах хэрэгтэй. Мөн маргаан бүхий акт нь хэдийгээр нийтэд дагаж мөрдөгддөг акт хэдий ч нэхэмжлэгч хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад зөвхөн өөрт холбогдуулан урьдчилсан хамгаалалт авах буюу актын биелэлтийг зөвхөн өөрт хамааруулан түдгэлзүүлэхээр шаардах эрхтэй байх нь нэхэмжлэгчийн эрхийг хамгаална.
17	120.3, 126.6	“... хэргийн бүх оролцогч, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн гомдол гаргасан тохиолдолд” гэснийг “... хэргийн бүх оролцогч гомдол гаргасан, эсхүл нийтийн ашиг сонирхлыг төлөөлөн нэхэмжлэл гаргасан” гэж өөрчлөн найруулах	Тухайн заалтын агуулгыг дэмжиж байгаа ч найруулгын үүднээс зөв болгох санал боловсруулав.
18	121.4	“... 14 ” гэж заасныг “7” болгон өөрчлөх.	Давж заалдах шатны шүүхээс гарах магадлалыг бичгээр бэлэн болгож гаргах хугацааг 7 хоногоор тогтоох нь зүйтэй. Учир нь, одоогийн хуулийн зохицуулалт тийнхүү 7 хоног гэдэг байдлаар зохицуулсан бөгөөд Шүүхийн тухай хуулиудын хүрээнд Давж заалдах шатны шүүхийн шүүгчийн орон тоо нэмэгдсэн, ачаалал багатай байдаг тул 7 хоногийн хугацаа хангалттай юм. Түүнчлэн, хуулийн төслийн хүрээнд Давж заалдах шатны шүүх хэргийг бүхэлд нь хянах бус зөвхөн давж заалдах гомдлын хүрээнд хянах тул шүүхийн ачаалал тодорхой хэмжээгээр буурна.
19	128.1	Тус заалтыг бүхэлд нь “Хяналтын шатны шүүх хуралдаан хэзээ, хаана болохыг хэргийн оролцогч, төлөөлөгч, өмгөөлөгчид мэдэгдэнэ” гэж өөрчлөх.	Хуулийн төслийн 117.5 дахь заалттай холбогдуулан гаргасан саналын тайлбар, үндэслэлтэй ижил.

Дугаарыг эрхэлсэн: Б.Хишигсайхан, ННФ-ын  
Засаглалын хөтөлбөрийн менежер

Дугаарт оролцсон: Ж.Даваасүрэн, Хуульч

Хаяг: Жамъян гүний гудамж - 5/1  
Сүхбаатар дүүрэг,  
Улаанбаатар - 14240  
Монгол Улс

Утас: 976-11-313207  
Факс: 976-11-324857  
Вэб: www.forum.mn  
И-мэйл: osf@forum.mn